

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/270/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ХҮМҮҮН ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УБЦТС	Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

2024.02.25 № 4/111
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Тайлант 1,258,638.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

019020189

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	412,644,996.55	772,346,247.63
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	72,113,664.31	397,070,411.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	72,113,664.31	397,070,411.49
3121	Төгрөг	72,113,664.31	397,070,411.49
31	Төрийн сангийн харилцах	72,113,664.31	397,070,411.49
35	БАРАА МАТЕРИАЛ	340,531,332.24	375,275,836.14
354	Хангамжийн материал	340,531,332.24	375,275,836.14
35410	Бичиг хэргийн материал	2,677,005.00	221,630.00
35420	Аж ахуйн материал	21,800.00	0.00
35450	Барилгын засварын материал	9,788,140.00	0.00
35460	Хүнсний материал	0.00	14,958,450.00
35470	Бусад хангамжийн материал	328,044,387.24	360,095,756.14
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,990,887,410.14	6,852,518,885.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,990,887,410.14	6,852,518,885.79
392	Биет хөрөнгө	5,008,569,128.90	5,870,959,745.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,876,713,283.00	5,741,763,061.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(726,136,183.44)	(910,729,797.48)
39205	Машин тоног төхөөрөмж	732,956,304.31	870,515,300.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	(299,442,742.04)	(239,404,203.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	526,123,502.54	497,626,846.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(147,041,495.26)	134,207,922.18
39217	Номын фонд	45,396,459.79	45,396,459.79
393	Биет бус хөрөнгө	982,318,281.24	981,559,140.48
39301	Программ хангамж	2,277,422.00	2,277,422.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(759,140.76)	(1,518,281.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	980,800,000.00	980,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,403,532,406.69	7,624,865,133.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	11,816,968.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	11,816,968.99
413	Өглөг	0.00	11,816,968.99
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	11,816,968.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,403,532,406.69	7,613,048,164.43
51	Засгийн газрын хувь оролцоо	6,403,532,406.69	7,613,048,164.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,563,489,068.49	3,563,489,068.49
51101	Өмч:-төрийн	3,563,489,068.49	3,563,489,068.49
512	Хуримтлагдсан үр дүн	(1,259,969,917.84)	224,669,567.51
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,259,969,917.84)	(984,846,190.23)
51220	Тайлант үеийн үр дүн		1,209,515,757.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,100,013,256.04	3,824,889,528.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,403,532,406.69	7,624,865,133.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,282,732,184.17	8,030,464,951.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,880,728,784.17	1,278,382,551.96
120	Нийтлэг татварын бус орлого	6,576,845,884.17	1,278,382,551.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,576,845,884.17	1,277,981,903.96
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,098,000.00	19,343,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	400,648.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	6,560,747,884.17	1,193,602,538.10
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	0.00	65,036,365.86
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	4,303,882,900.00	0.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	4,303,882,900.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,402,003,400.00	6,752,082,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		5,665,569,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,315,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	330,315,000.00	0.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,071,688,400.00	1,086,512,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага /	1,071,688,400.00	1,086,512,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,879,199,777.48	6,820,949,194.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,879,199,777.48	6,820,949,194.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,204,027,637.48	6,459,769,293.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,269,218,960.00	4,056,309,797.47
210101	Үндсэн цалин	2,135,842,568.00	2,537,903,684.60
210102	Нэмэгдэл	1,019,192,189.00	1,426,693,050.87
210104	Урамшуулал	114,184,203.00	91,713,062.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	409,146,234.69	509,686,792.35
210201	Тэтгэврийн даатгал	281,085,846.31	348,891,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	33,082,320.41	41,046,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,230,656.68	32,836,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,247,798.00	7,901,017.41
210205	Эрүүл мэндийн даатгал	62,499,613.29	79,010,474.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	909,030,905.00	1,091,474,778.04
210301	Гэрэл, цахилгаан	34,008,262.00	54,709,468.99
210302	Түлш, халаалт	827,112,400.00	971,928,163.04
210303	Цэвэр, бохир ус	47,910,243.00	64,837,146.01

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	38,001.40	0.00
210401	Бичиг хэрэг	38,001.40	0.00
2105	Норматив зардал	92,069,270.00	136,566,940.00
210502	Хоол, хүнс	92,069,270.00	136,566,940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,032,695.00	6,854,000.00
210604	Урсгал засвар	2,032,695.00	6,854,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,513,200.00	37,228,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,098,000.00	19,343,000.00
210806	Мэдээллийн технологийн хөлс	2,415,200.00	17,885,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	503,978,371.39	621,648,285.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,209,394.47	127,887,422.96
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	23,112,279.44	52,373,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	371,656,697.48	441,387,662.45
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	675,172,140.00	361,179,900.95
	Бусад урсгал шилжүүлэг	670,966,264.00	361,178,910.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	81,283,700.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	248,681,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	0.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг	4,205,876.00	990.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,205,876.00	990.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,403,532,406.69	1,209,515,757.74
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,403,532,406.69	1,209,515,757.74

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,563,489,068.49	4,100,013,256.04	(1,535,637,463.40)	6,127,864,861.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(6,127,864,861.13)	(6,127,864,861.13)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,563,489,068.49	4,100,013,256.04	(7,663,502,324.53)	-
Тайлант үеийн үр дүн			6,403,532,406.69	6,403,532,406.69
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,563,489,068.49	4,100,013,256.04	(1,259,969,917.84)	6,403,532,406.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	275,123,727.61	275,123,727.61
Дахин илэрхийлсэн	3,563,489,068.49	4,100,013,256.04	(984,846,190.23)	6,678,656,134.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(275,123,727.61)	-	(275,123,727.61)
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/	-	-	1,209,515,757.74	1,209,515,757.74
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,563,489,068.49	3,824,889,528.43	224,669,567.51	7,613,048,164.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,721,984,300.00	6,771,826,048.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,319,980,900.00	19,743,648.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,098,000.00	19,743,648.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,098,000.00	19,343,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,098,000.00	19,343,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	400,648.00
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	4,303,882,900.00	0.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	4,303,882,900.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,402,003,400.00	6,752,082,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		5,665,569,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		5,665,569,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	330,315,000.00	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	330,315,000.00	0.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,071,688,400.00	1,086,512,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага /	1,071,688,400.00	1,086,512,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,491,549,885.69	6,337,452,700.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,491,549,885.69	6,337,452,700.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,816,377,745.69	5,961,314,349.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,269,218,960.00	4,056,309,797.47
210101	Үндсэн цалин	2,135,842,568.00	2,537,903,684.60
210102	Нэмэгдэл	1,019,192,189.00	1,426,693,050.87
210104	Урамшуулал	114,184,203.00	91,713,062.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	409,146,234.69	509,686,792.35
210201	Тэтгэврийн даатгал	279,132,410.89	348,891,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	32,772,607.08	41,046,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,160,925.49	32,836,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,459,887.37	7,901,017.41
210205	Эрүүл мэндийн даатгал	64,620,403.86	79,010,474.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	909,030,905.00	1,079,657,809.05
210301	Гэрэл, цахилгаан	34,008,262.00	42,892,500.00
210302	Түлш, халаалт	827,112,400.00	988,666,100.00
210303	Цэвэр, бохир ус	47,910,243.00	48,099,209.05

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Норматив зардал	92,069,270.00	136,566,940.00
210502	Хоол, хүнс	92,069,270.00	136,566,940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	12,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,96,9300.00	37,228,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,098,000.00	19,343,000.00
210806	Мэдээллийн технологийн хөлс	2,871,300.00	17,885,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,943,076.00	135,010,311.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,732,536.00	82,637,111.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,210,540.00	52,373,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	675,172,140.00	376,138,350.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	670,966,264.00	376,137,360.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	340,801,264.00	376,137,360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	81,283,700.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	248,681,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	0.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг	4,205,876.00	990.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,205,876.00	990.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	230,434,414.31	434,373,347.18
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	158,320,750.00	109,416,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	158,320,750.00	109,416,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	158,320,750.00	109,416,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	158,320,750.00	109,416,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(158,320,750.00)	(109,416,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	72,113,664.31	324,956,747.18
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	72,113,664.31
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	72,113,664.31	397,070,411.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		72,113,664.31	(72,113,664.31)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,840,176,600.00	6,446,869,300.82	393,307,299.18	94.3%
УРСГАЛ ЗАРДАЛ	6,840,176,600.00	6,446,869,300.82	393,307,299.18	94.3%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,399,892,100.00	6,070,730,949.87	329,161,150.13	94.9%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,287,902,300.00	4,056,309,797.47	231,592,502.53	94.6%
Үндсэн цалин	2,978,726,300.00	2,537,903,684.60	440,822,615.40	85.2%
Нэмэгдэл	1,171,664,600.00	1,426,693,050.87	(255,028,450.87)	121.8%
Урамшуулал	137,511,400.00	91,713,062.00	45,798,338.00	66.7%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	535,988,100.00	509,686,792.35	26,301,307.65	95.1%
Тэтгэврийн даатгал	364,472,000.00	348,891,900.00	15,580,100.00	95.7%
Тэтгэмжийн даатгал	42,878,900.00	41,046,500.00	1,832,400.00	95.7%
ҮОМШӨ-ний даатгал	34,303,200.00	32,836,900.00	1,466,300.00	95.7%
Ажилгүйдлийн даатгал	8,575,900.00	7,901,017.41	674,882.59	92.1%
Эрүүл мэндийн даатгал	85,758,100.00	79,010,474.94	6,747,625.06	92.1%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,079,658,800.00	1,079,657,809.05	990.95	100.0%
Гэрэл, цахилгаан	42,892,500.00	42,892,500.00		100.0%
Түлш, халаалт	988,666,100.00	988,666,100.00		100.0%
Цэвэр, бохир ус	48,100,200.00	48,099,209.05	990.95	100.0%
Норматив зардал	141,873,900.00	136,566,940.00	5,306,960.00	96.3%
Хоол, хүнс	141,873,900.00	136,566,940.00	5,306,960.00	96.3%
Эд хогшил, урсгал засварын зардал	6,854,000.00	6,854,000.00		100.0%
Урсгал засвар	6,854,000.00	6,854,000.00		100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	55,251,800.00	50,758,300.00	4,493,500.00	91.9%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,503,000.00	19,343,000.00	1,160,000.00	94.3%
Мэдээллийн технологийн зардал	34,748,800.00	31,415,300.00	3,333,500.00	90.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	292,363,200.00	230,897,311.00	61,465,889.00	79.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	239,839,300.00	178,524,111.00	61,315,189.00	74.4%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,523,900.00	52,373,200.00	150,700.00	99.7%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	440,284,500.00	376,138,350.95	64,146,149.05	85.4%

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусад урсгал шилжүүлэг	440,284,500.00	376,137,360.00	64,147,140.00	85.4%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	440,284,500.00	376,137,360.00	64,147,140.00	85.4%
Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг		990.95	990.95	
Төвлөрүүлэх шилжүүлэг		990.95	990.95	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,772,986,100.00	6,771,826,048.00	1,160,052.00	100.0%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,665,569,600.00	5,665,569,600.00	0.00	100.0%
Улсын төсвөөс санхүүжих	5,665,569,600.00	5,665,569,600.00	0.00	100.0%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,086,512,800.00	1,086,512,800.00	0.00	100.0%
Орон нутгийн төсвөөс	1,086,512,800.00	1,086,512,800.00	0.00	100.0%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	20,903,700.00	19,743,648.00	1,160,052.00	94.5%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,503,000.00	19,343,000.00	1,160,000.00	94.3%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,700.00	400,648.00	52.00	100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		72,113,664.31	(72,113,664.31)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		397,070,411.49	(397,070,411.49)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	212.00	209.00	3.00	98.6%
Удирдах ажилтан	1.00	1.00		100.0%
Гүйцэтгэх ажилтан	157.00	154.00	3.00	98.1%
Үйлчлэх ажилтан	54.00	54.00		100.0%

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,086,512,800.00	1,086,512,800.00		100.0%
УРСГАЛ ЗАРДАЛ	1,086,512,800.00	1,086,512,800.00		100.0%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,086,512,800.00	1,086,511,809.05	990.95	100.0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,079,658,800.00	1,079,657,809.05	990.95	100.0%
Гэрэл, цахилгаан	42,892,500.00	42,892,500.00		100.0%
Түлш, халаалт	988,666,100.00	988,666,100.00		100.0%
Цэвэр, бохир ус	48,100,200.00	48,099,209.05	990.95	100.0%
Эд хогшил, урсгал засварын зардал	6,854,000.00	6,854,000.00		100.0%
Урсгал засвар	6,854,000.00	6,854,000.00		100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		990.95	(990.95)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,086,512,800.00	1,086,512,800.00		100.0%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,086,512,800.00	1,086,512,800.00	0.00	100.0%
Орон нутгийн төсвөөс	1,086,512,800.00	1,086,512,800.00	0.00	100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
АЖИЛЛАГСДЫН ТОО	212.00	209.00	3.00	98.6%
Удирдах ажилтан	1.00	1.00		100.0%
Гүйцэтгэх ажилтан	157.00	154.00	3.00	98.1%
Үйлчлэх ажилтан	54.00	54.00		100.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын алсын хараа нь “Хүмүүнлэг Монгол иргэнийг төлөвшүүлнэ”, байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь сургалтын үйл ажиллагаа. Эрхэм зорилго нь хүсэл эрмэлзэлтэй, үнэнч шударга, мэдлэг чадвартай, үүрэг хариуцлагатай, үлгэрлэн манлайлагч, нэр хүндтэй суралцагч гэж тодорхойлжээ.

2023-2024 оны хичээлийн жилд тавьсан зорилго нь ээлжит хичээл бүрийг чанар, үр дүнтэй зохион байгуулах замаар сурлагын амжилтыг ахиулах, багш ажлын байрандаа тасралтгүй хөгжиж, бие даан суралцах чадвартай сурагчдыг бэлтгэх, орчин үеийн шаардлагад нийцэхүйц хүүхдэд ээлтэй, аюулгүй сургалтын орчин бүрдүүлэх сургуулийн менежментийг сайжруулах сурагчдын сурлагын амжилтыг ахиулна гэсэн байна.

Гүйцэтгэлийн үр дүнгийн төлөвлөгөө гарган батлуулж түүний дагуу ажлаа төлөвлөж жилд 2 удаа тайлан бэлтгэж өгдөг

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, хэрэгжүүлэх 59 арга хэмжээтэй баталснаас нийт 91,2 %-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургууль нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургууль нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,221,332.7 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	72,113.7	397,070.4	324,956.7
Бараа материал	340,531.3	375,275.8	34,744.5
Үндсэн хөрөнгө	5,990,887.4	6,852,518.9	861,631.5
Нийт хөрөнгө	6,403,532.4	7,624,865.1	1,221,332.7
Өглөг	-	11,817.0	11,817.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,563,489.1	3,563,489.1	-
Хуримтлагдсан үр дүн	1,259,970.0	224,669.5	1,209,515.7
Дахин үнэлгээний нэмэгдэл	4,100,013.3	3,824,889.5	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,403,532.4	7,624,865.1	1,221,332.7

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 324,956.7 мянган төгрөгөөр өссөн нь төсөв гүйцэтгэлээр санхүүждэгтэй холбоотой.

Бараа материал данснаас 32,128.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгаснаас буурч, мөн 65,036.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж 865,049.8 мянган төгрөг, тоног төхөөрөмж 379,035.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 58,934.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 328,907.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 109,416.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг худалдан авч, 1,193,602.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан нь үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,816.9 мянган төгрөг орон нутгийн тогтмол зардлын тодотгол нэмэгдээгүйтэй холбоотой гэрэл, цахилгааны өр үүссэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,613,048.2 мянган төгрөг болж 1,209,515.8 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,372,264.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 988,900.9 мянган төгрөг, нийт

6,361,165.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургууль нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 479,011.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 6,840,176.6 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 6,840,176.6 мянган төгрөгөөс 2 удаа тодотгол хийж 6,840,176.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,840,176.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулсан байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,446,869.3 мянган төгрөг буюу 94,3 хувьтай байна.

Хүснэгт 2.

/мянган төгрөг/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	80266-Байр ашиглалтын үйлчилгээ	13,899.5	13,898.9	0.6	100%
1.2	80312-Сургалт, семинар	6,949.8	6,882.0	67.8	99%
1.3	81605-Эрүүл мэндийг дэмжих	13,899.5	9,941.0	3,958.5	71.5%
1.4	81801-Үдийн цай хөтөлбөр	440,284.5	376,137.4	64,147.1	85.4%
1.5	81806-Дотуур байрны үйлчилгээ	200,678.5	186,625.3	14,053.2	93%
1.6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	146,366.8	95527.0	50839.8	65.2%
1.7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	35,413.3	29,574.0	5839.3	85,8%
1.8	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	4829.9	995.2	3834.7	20.6%
1.9	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	4,219,984.6	3,970,934.2	249,050.4	94%
1.10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	650,453.7	650,097.9	355.8	99.9%
1.11	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	400.7	400.6	0.1	100%
1.12	81848-Сурах бичгийн түрээс	20,503.0	19,343.0	1,160.0	94.3%
1.13	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	1,086,512.8	1,086,511.8	0.9	100%
	Дүн	6,840,176.6	6,446,868.3	393,308.3	94.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 1,569,261.4 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоол хүнс 469,097.2 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 91,333.1 мянган төгрөгийн бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, томиллолт, тээвэр шатахуун, төлбөр

хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, мэдээлэл технологийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 921,959.1 мянган төгрөгийн тогтмол зардал, 86,872.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлаас шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 1,764,636.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Худалдан авалтын дүн өссөн нь түлш халаалтын үнэ нэмэгдсэн, сурагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар авлага, өглөгийг баталгаажуулан барагдуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23 -ны өдрийн 24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээ тус сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 5,879,199.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 88,187.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 66,141.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, норматив зардлыг 5,306.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4,495.6 мянган төгрөг, нийт 9,802.5 мянган төгрөгийг хэмнэн зарцуулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 159 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй ба нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 172 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	21,021.9	1	21,021.9	100%
Зөвлөмж	1	12,513.2	1	12,513.2	100%
Нийт дүн	2	33,535.1	2	33,535.1	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын Хүмүүн цогцолбор сургуулийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,816.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 11,816.9 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 2 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд УБЦТС-д цахилгааны төлбөр 11,816.9 мянган төгрөгийн өглөгийг баталгаажуулан барагдуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Үүссэн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулан холбогдох хуулийг хэрэгжүүлэх

2. Хандив тусламжийн хөрөнгийг бүртгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд төгсөгчид болон иргэдээс авсан хандив тусламжаар үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа "Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан"-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1-д "Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль /цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг "Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан"-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Хандив тусламжийн хөрөнгийг бүртгэхтэй холбогдох хуулийг хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өглөгийг тооцоо нийлж барагдуулах	1	11,816.9					1	11,816.9				
Хандив, тусламжийн хөрөнгийг бүртгэх	1						1	-				
Дүн	2	11,816.9					2	11,816.9				